



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-16</i>
<hr/>	
<i>1.Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.12.30-ны өдөр ирүүлсэн/</i>	<i>4-16</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 64.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ё.Баатарбилэг, Х.Булгантуяа, Н.Наранбаатар, Х.Нямбаатар, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ц.Мөнх-Оргил, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Э.Батшугар, Д.Ганбат, Н.Ганибал, Б.Жавхлан, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар;

Хоцорсон: С.Батболд-46 минут, Ж.Бат-Эрдэнэ-10 минут, Д.Өнөрболор-16 минут, Б.Саранчимэг-26 минут, Ч.Ундрэм-32 минут, Н.Учрал-30 минут.

Нэг.Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.12.30-ны өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Эрдэнэсийн сангийн хэлтсийн дарга П.Эрдэнэтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Сандаг-Очир, Б.Батгөмөр нарын тавьсан асуултад Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 16

Бүгд: 45

64.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:57/

Уг асуудлыг 10 цаг 58 минутад дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын урилгаар Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ЕБС-ийн мини парламент клубийн сурагчид, иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Хялганат тосгоны “Хараацай” чуулгын багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 50 минут үргэлжилж, 73 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 72.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Ирц бүрдсэн тул чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье.

Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж, мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэхийн өмнө 2, 3 асуудал танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.1-д хууль, тогтоомж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм эдийн засгийн санхүүгийн төлөв байдал болон цаг үеийн тулгамдсан бусад асуудлаар Засгийн газраас сар бүрийн 1 ба 3 дахь 7 хоногийн баасан гаргийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд тогтмол мэдээлэл хийж Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдээс амаар тавьсан асуултад хариулна гэж. Мөн хуулийн 110.2-т асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2, 4 дэх, 7 хоногийн баасан гаргийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд

шаардлагатай бол баасан гаргийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно гэж тус тус заасны дагуу энэ 7 хоног буюу 3 дугаар сарын 5 дахь 7 хоногт одоо тав дахь 7 хоног энэ 31-нд таарч байгаа учраас асуулгын хариу мэдээлэл 2 бол алга байна. Хоёулаа 1, 3 дахь 7 хоног 2, 4 дэх 7 хоног гэсэн. Тав дахь 7 хоног гэж ийм цонх гарч байгаа юм байна.

Тийм учраас энэ тав дахь өдөр бол асуулгын хариу болон мэдээллийг сонсохгүй нь байна. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Нэгдсэн хуралдааны дараа. Нийгмийн бодлогын байнгын хорооны Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан Үндсэн хууль танхимд болно. БСШУС-ын байнгын хорооны Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан Их Засаг танхимд болно. Хэлэлцэх асуудалдаа орно.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут танилцуулна.

Дамбын Батлут гишүүнийг индэрт урьж байна.

Ажлын хэсгийг оруулъя.

Д.Батлут: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд Улсын Их Хурлаас Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын болон байнгын бус хэсэгт байх эрдэнэсийн нэр төрөл, хэмжээг тогтоох, Үндсэн сангийн жилийн орлого, зарлагын

хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах Үндсэн сангийн байнгын бус хэсгээс үнэт металл, үнэт чулуу худалдах, худалдан авах шийдвэр гаргах, олборлосон үнэт металл, үнэт чулууг Эрдэнэсийн санд худалдан авах доод хэмжээг тогтоохоор заасныг болон Монголбанкнаас ирүүлсэн санал түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн сан болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, уг тогтоолын төслийг 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрөөтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг Улсын Их Хурлын шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан бол холбогдох Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн сан болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал

дүгнэлтийг хэлэлцсэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Цэндийн Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Ш.Адьяа: Өнөөдөр энэ Эрдэнэсийн сангийн тухай мэдээллийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа. Монгол Улсын эрдэнэсийн сан хөмрөг бол өнөөдөр Монгол Улсын үнэт баялгийн 1 хэсэг гэж үзэж байгаа. Энэ эрдэнэсийн сангийн одоо үйл ажиллагаа ер нь олон нийтэд нээлттэй байдаг уу? Энэ Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа үнэт ховор одоо Эрдэнэсийн сангийн үнэт зүйлүүдийн зарж борлуулах асуудал ер нь хуулийн хүрээнд сүүлийн жилүүдэд ер нь ямар хэмжээнд явагдаж байгаа вэ? Ер нь Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа үнэт зүйлүүд зарим одоо хувь хүмүүсийн гарт очиж тэр эрдэнэсийн санд байсан тэр үнэт үзмэрүүд, ялангуяа энэ хөөрөг болон бусад үнэт чулуунууд Эрдэнэсийн санд хадгалагдаж байсан гэсэн ийм каталогууд гараад байгаа. Ийм одоо үзмэрүүд хувь хүний үзмэрүүд дээр энэ гараад байгаа.

Түүнчлэн энэ 2000 оны эхэн үед Эрдэнэсийн санд байсан Юань улсын их хэмжээний мөнгөн ембүүг гадагшаа гаргасан тийм асуудал бол байдаг. Энэ үнэт зүйл цаашидаа ийм байдлаар явагдах ийм алдаа дахин одоо давтагдахгүй талаар Монголбанк Эрдэнэсийн сан ямар бодолтой байна аа?

Түүнчлэн өнөөдөр энэ Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа үнэт зүйлийг ямар журмаар одоо зарж борлуулдаг вэ?

Түүнчлэн энд Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа зүйлийг дуудлага худалдаагаар зардаг юм уу аль эсвэл тэрийг худалдаж авъя гэсэн иргэд ААН-үүдэд өгөх ийм хууль эрх зүйн зохицуулалт байна уу? Түүнчлэн одоо сүүлийн жилүүдэд Эрдэнэсийн санд үнэт зүйл ховор зүйлийг одоо хэчнээн хэмжээгээр худалдаж авсан тухай мэдээллийг нэг сонсьё. Түүнчлэн Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа зүйлийг одоо зарж борлуулах энэ асуудалд санал тавихад энэ нээлттэй байдаг юм уу гэсэн ийм одоо 2, 3 асуултад хариулт авмаар байна.

Г.Занданшатар: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулна.

Г.Энхтайван: Адьшаа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хууль хуулийн шинэчилсэн найруулга өнгөрсөн жилийн одоо 3 дугаар сард хурал шинэчлэн батлагдсан байгаад байгаа. Тэгэхээр шинээр батлагдсан энэ эрдэнэсийн сангийн хуулийн шинэчилсэн найруулгаар эрдэнэсийн сангийн хадгалалт, харуул хамгаалалттай холбоотой хэсгээс бусад бүх зүйл улсын болон албаны нууцаас гарсан байгаад байгаа.

Тэгэхээр эрдэнэсийн санд бүртгэлтэй байгаа эд хөрөнгө зүйлс болон одоо бусад эдгээртэй холбоотой мэдээлэл ил нээлттэй байгаад байгаа. Тэгэхээр бол төв банк өөрийн веб сайт болон бусад одоо холбогдох мэдээллийн хэрэгслээрээ эрдэнэсийн сангийн одоо орлого, зарлага, үндсэн болон гүйлгээ, сангийн зарлага болон бусад мэдээ мэдээллийг бол дэлгэрэнгүй өгч байгаа.

Эрдэнэсийн санд ямар процедураар эд зүйлс одоо бүртгэж, худалдаж авдаг вэ гэдэг дээр тайлбар хэлье. Эрдэнэсийн сангийн тухай хуульд зааснаар эрдэнэсийн үйл ажиллагаанд мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгдөг. Эрдэнэсийн

сангийн мэргэжлийн зөвлөл гэж ажилладаг. Мэргэжлийн зөвлөлийг Шинжлэх ухааны академ, Соёлын яам, МУИС болон холбогдох бусад одоо түүх, археологи, одоогийн хүрээлэнгүүд болон эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан Үндэсний зөвлөл мэргэжлийн зөвлөл ажилладаг. Энэ мэргэжлийн зөвлөл өөрсдөө санал, дүгнэлтээ гаргаад мэргэжлийн зөвлөлийн гаргасан санал, дүгнэлтийн дагуу Монголбанкны эрдэнэсийн санг арвижуулдаг. Мөн Эрдэнэсийн сангийн одоо зарлагатай холбоотой асуудал дээр гишүүн тодрууллаа. Эрдэнэсийн сан маань өөрөө үндсэн болон гүйлгээ сан гэж хуваагддаг.

Үндсэн сан маань байнгын ба байнгын бус гэж дотроо хуваагддаг байгаад байгаа. Байнгын хэсэгт Монгол Улсын одоо эрдэнэсийн санд байнгын хэсэгт бүртгэгдсэн аливаа эд зүйлс одоо үнэт олдворыг бол ямар нэгэн хэлбэрээр эрдэнэсийн сангаас гадагшлуулах, зарж борлуулах, бусдад шилжүүлэх нь бол хуулиар хориотой байдаг.

Эрдэнэсийн сангийн байнгын бус хэсэгт байгаа эд зүйлсийг бол зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрээр бусдад шилжүүлэх зарж борлуулах зөвшөөрлийг олгодог байгаад байгаа. Тэгэхээр бол сүүлийн одоо Эрдэнэсийн сангийн тухай хууль батлагдсанаас хойш 1994 оноос хойш Улсын Их Хурал ийм шийдвэр гаргаагүй байгаа учраас Улсын Их Хурлын шийдвэргүйгээр Эрдэнэсийн сангийн одоо үндсэн сангаас ямар нэгэн эд зүйлс бол гараагүй гэсэн үг ээ.

Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас бол одоо Улсын Их Хуралд танилцуулж энэ төсөв батлуулсны хүрээнд бол Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас бол зарлага бол гаргадаг. 2022 онд бол Монголбанк нийт 2 тэрбум төгрөгөөр бол түүх, соёлын, дурсгалт зүйлс, байгалийн төрц худалдан авах гэх мэтчилэн археологийн олдвор шилжүүлэн

авахаар төсөвлөөд бол 954 сая төгрөгийг бол бид нар төсвийн гүйцэтгэлээрээ бол худалдаж авсан байгаад байгаа. Нийтдээ 200 орчим ширхэг дурсгалын зоос үндсэн сангийн орлогод бас 108 ширхгийг нь бол авсан байгаад байгаа.

Мөн Монгол банкны мөнгөн тэмдэгтийн газраас 165 ширхэг зоос болон мөнгөн тэмдэгтийг эрдэнэсийн сангийн тэнцлээс гадуурах данснаас бол шилжүүлэн бүртгэсэн байгаад байгаа. Эрдэнэсийн сангийн бол бусад одоо энэ орлого, зарлагатай холбоотой бүх мэдээлэл бол нээлттэй байгаад байгаа. Улсын Их Хурлын гишүүдэд бол танилцуулахаар дэлгэрэнгүйг нь бол хүргүүлсэн байгаад байгаа.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн 1 минут нэмж тодруулж асууя.

Ш.Адьшаа: Одоо энэ иргэдийн гар дээр байгаа түүхийн үнэт зүйл ховор эдлэлийг та нар ямар журмаар худалдаж авдаг вэ? Түүнчлэн одоо энэ Дондогдуламын хөөрөг гээд нэг хүний гар дээр байгаа. Тэр бол яаж гарсныг нь ч одоо мэдэж байгаа. Ийм зүйлийг одоо бодлогын хэмжээнд төр худалдаж авах ийм боломж байгаа юу? Монголбанк. Түүнчлэн дээр нь энэ Монгол банканд одоо энэ эрдэнэсийн гол чухал зүйл болох энэ алт цэвэршүүлэх асуудал дээр энэ Монгол банканд ямар журмаар явагддаг вэ? Энэ дээр хувийн ААН-үүд энэ алт цэвэршүүлэх алтны баталгаа гаргахад оролцдог тухай ийм мэдээлэл байдаг.

Ийм ямар ААН-үүд байдаг юм? Энийг ямар журмаар энэ шалгаруулж ийм үйл ажиллагааг явуулах зөвшөөрлийг хаанаас өгдөг вэ гэдэг энэ 2.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбатын урилгаар

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ЕБС-ийн мини парламент клубийн сурагчид, иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Энхтайван Дэд ерөнхийлөгч асуултад хариулъя.

Г.Энхтайван: Ард иргэдийн гар дээр болон одоо зах зээл дээр байгаа Эрдэнэсийн санд байх боломжтой эд зүйлсийн жагсаалтыг бол Соёлын өвийн үндэсний төвийн дүгнэлтээр Монголбанканд өөрсдөө хүсэлт гаргасны үндсэн дээр Монголбанкны эрдэнэсийн мэргэжлийн зөвлөл дүгнэлт гаргаад бид бүхэн бол дотооддоо худалдан авах үйл ажиллагааг явуулдаг. Тэр Соёлын өвийн тухай хууль дээр түүх соёлын хосгүй үнэт, үнэт гэсэн тийм ангиллыг гаргаж өгдөг.

Тэгэхээр түүх соёлын хосгүй үнэт зүйлсийг Соёлын өвийн үндэсний төвд тодорхойлоод Соёлын өвийн үндэсний төв тодорхойлсны дараа Монголбанкны одоо мэргэжлийн эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцээд мэргэжлийн зөвлөл энэ нь эрдэнэсийн санд заавал байх ёстой эд зүйлс мөн юм гээд дүгнэлт гаргасан тохиолдолд Монголбанк худалдаж авдаг.

Ер нь бол ард иргэд болон одоо бусад одоо хувийн сектороос энэ эрдэнэсийн санд эд зүйлс худалдахаар бол саналыг.

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Энхтайван 83.

Г.Энхтайван: Ард иргэдээс эрдэнэсийн санд тэр эд зүйлс худалдах саналыг бол байнга тавьдаг. Тэгээд төв банкны зүгээс бол энэ Соёлын өвийн үндэсний төв болон Соёлын яам бусад энэ

соёлын өвийн асуудал эрхэлж байгаа төрийн захиргааны төв байгууллагатай хамтраад тэдгээрийн дүгнэлтийн дагуу бол төв банк бол энийг худалдаж авч эрдэнэсийн санг бол тухай бүрд нь баяжуулдаг. Алт цэвэршүүлэхтэй холбоотой асуудал дээр бол Төв банк олон улсын жишиг стандартынхаа дагуу Лондонгийн металлын бирж дээр одоо лиценз авсан олон улсын алт цэвэршүүлэх үйлдвэрээр дамжиж алтыг цэвэршүүлдэг. Яг одоогийн байдлаар бол Швейцарын аргор гэж үйлдвэртэй Монголбанк бол хамтраад ажилладаг үйлдвэрүүдийг сонгон шалгаруулах процессыг бол Төв банкнаас бол 3 жилийн хугацаатай давтамжтайгаар явуулдаг. Лондоны металлын эксченжээс одоо тэр үнэт металл алт цэвэршүүлэх үйлдвэрийн жагсаалтыг бол тухай бүрдээ жил болгон одоо жилдээ 2 удаа ингээд шинэчлээд баталдаг. Энэ жагсаалтын хүрээнд Монголбанк сонгон шалгаруулалтаа явуулдаг.

Г.Занданшатар: Одоо Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж үг хэлнэ.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Эрдэнэсийн сангийн 2022 оны тайланг хэлэлцэж байна. Тайлангаас харахад 2022 онд хэд хэдэн худалдан авалт хийсэн байна. Төрц алт, Жадамба судар, Монголын эзэнт гүрний хаадын зоос эд нар гээд нийт дүнгээрээ 954 сая төгрөгийн худалдан авалт. Энэ худалдан авалтыг ямар хуулийн хүрээнд худалдан авалт хийдэг юм бэ? Аль хуулиар зохицуулагдаж байна вэ? Шууд гэрээгээр юм уу энэ дээр тайлбар өгөөч?

Нөгөө талаар олон нийтийн дунд бас энэ эрдэнэсийн сангаас ховор түүхэн зураг алдагдах, алдагдсан баримал, уран баримал, бурхад алдагдсан гээд ярианууд байдаг. Энэ хэр бодитой байдаг юм бэ? Ер нь Эрдэнэсийн сангаас ийм одоо ховор түүхийн эд өлгийн зүйлүүд алдагдсан зүйлүүд ер нь одоо ямар байдаг юм?

Байсан бол? Одоо энэхүү ямар арга хэмжээ авсан юм. Энэ ер нь хэр олон нийтийн дунд ил тод нээлттэй байдаг юм? Нууц байх ёстой юм уу? Энэ дээр 1 хариулт өгөөч.

Дараагийн зүйл энэ эрдэнэсийн санд ер нь өнөөдрийн байдлаар хэчнээн нэр төрлийн хэчнээн ширхэг энэ одоо эд өлгийн зүйл хадгалаатай байдаг юм. Энэ аялал жуулчлалын жилийн хүрээнд бас 1 гадна, дотнын хүмүүст үзүүлж харуулчих юм бол энэ эрдэнэсийн сангийн энэ одоо түүхэн ховор эд өлгийн зүйлсийг үзүүлж харуулах асуудал шүү дээ. Бас нэг үзчихье. Энэ Монголын эзэнт гүрэн дэлхийн дайдыг эзэлж байсан улс орон ер нь ямар хэмжээний эрдэнэсийн сантай байдаг юм. Энэ нь олон нийтэд хэр нээлттэй байдаг юм? үзүүлж харуулах бололцоо боломж нь юу байдаг юм? Одоо ганц Чингис хааны музейгээсээ өөр үзүүлэх юмгүй л байж байна шүү дээ. Тэгээд энийг цаашидаа олон нийтэд нээлттэй байлгах тал дээр ер нь одоо ямар бодлого барьж ажилладаг юм бэ гэсэн ийм 3 асуулт асууя.

Г.Занданшатар: Баярлалаа. 83 Энхтайван.

Г.Энхтайван: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Эрдэнэсийн санд түүх соёлын хосгүй үнэт болон үнэт үзмэрүүдийг Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу бид бүхэн бол худалдан авдаг. Эрдэнэсийн сангийн тухай хуулиар хуульд зааснаар Монгол Улсын Соёлын өвийн тухай хуульд заасан түүх соёлын хосгүй үнэт болон үнэт болон үнэт гэж ангилагдсан зэрэглэл авсан түүх соёлын дурсгалт зүйлсийг Соёлын өвийн үндэсний төвийн дүгнэлтийн дагуу Монголбанкны Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцээд гарсан дүгнэлтийн дагуу Төв банкны эрдэнэсийн санд бол худалдаж авдаг.

Энэ үйл ажиллагаа нь Эрдэнэсийн сангийн тухай хуулиар зохицуулагддаг. Эрдэнэсийн санд одоо уран баримал болон уран зураг одоо хадгалагддаггүй. Анх 1984 онд Сайд нарын зөвлөлийн тогтоолоор үүсгэн байгуулагдахдаа үнэт металл эрдэнэсийн зүйлс хадгалахаар одоо анх зохион байгуулагдаж тийм үнэт металл, эрдэнэсийн зүйлээр хийгдсэн түүх соёлын хосгүй үнэт зүйлсүүд бол шилжиж ирсэн байдаг. Уран зураг, уран барималтай холбоотой хэсэг нь бол одоо Урчуудын эвлэл болон одоо бусад холбогдох музейнүүдэд шилжиж очсон байгаад байгаа.

Тэгэхээр бол яг ийм зүйлс бол хадгалагддаггүй ээ. Үзмэр болон бусад олон нийтэд үзүүлэхтэй холбоотой асуудал дээр бол Эрдэнэсийн сан нь яг өөрсдийн одоо үзмэрийн танхимтай. Энүүгээрээ бол тухай бүрдээ бол олон нийтэд үзмэрээ дэлгээд явуулдаг. Мөн одоо шинээр байгуулагдсан Чингис хаан музейтэй Эрдэнэсийн сан хамтраад одоо гэрээ байгуулсны үндсэн дээр Эрдэнэсийн сангийн хосгүй үнэт, үнэт үзмэрүүдийг бол энэ шинэ музейд бол дэглэн байршуулж ард иргэдэд үзүүлж байгаа.

Тэгэхээр энэ музей дээр очоод үзэхээр бол энэ үзмэр нь л Монголбанканд барьдаг эрдэнэсийн сангийн үзмэр юм гэсэн тийм тайлбартайгаар бол үзмэрүүдийг байршуулсан байгаад байгаа. Нийтдээ бол эрдэнэсийн санд I их наяд төгрөгийн үзмэрүүд байгаад байгаа. Эрдэнэсийн сангийн үзмэрийн тооллогыг бол жил болгон хөндлөнгийн аудитын байгууллага бол хийж гүйцэтгэдэг.

Эрдэнэсийн сангаас ямар нэгэн хэлбэрээр бол эд зүйлс, түүх соёлын хосгүй үнэт зүйлс бол алдагдаагүй ээ. Энэ дээр бол хөндлөнгийн аудитын байгууллага болон одоо бусад холбогдох энэ төрлийн хяналт шалгалт хийдэг байгууллагууд бол тухай бүрд нь хяналтаа тавьж явдаг.

Г.Занданшатар: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн асуулт асууя.

Б.Дэлгэрсайхан: Амрыг эрье. Энхтайван одоо би чамаас нэгэнт ороод ирсэн дээр чинь ашиглаад шал өөр юм асуух гэсэн юм. Энэ Монголбанк мөнгөний бодлогоо ер нь яаж явж байна аа? Энэ боломж олдсоныг ашиглаж байна л даа. Тэгээд Монголбанкны үүрэг бол үндсэндээ бол хувийн ААН компаниудыг удирддаг л ганц газар шүү дээ. Тэгээд энэ хувийн бүх ААН компаниуд чинь бүгд ийм дампуурлын ирмэг дээр дампуурчихсан л даа угаасаа. Мөнгө байхгүй тэгээд яагаад би энийг яагаад ярьж байгаа юм гэхлээр та нар яагаад ингээд зээлээ хумьчхав аа? Үндсэндээ Монгол Улсын эдийн засгийн цусны эргэлт үндсэндээ экспортыг эс тооцвол ингээд зогсчихсон. Тэгээд одоо энийгээ яах гэж байгаа юм бэ? Яг тодорхойгүй байдалд одоо ингээд хүмүүс хүлээлтийн байдалтай ингээд байж байна. Нөгөө хавар ер нь өвөл болоод цас ордог гэж ярьдаг шиг одоо хавар болоод том бүтээн байгуулалт эхлэх гээд олон хүмүүс ингээд бас ажлаа эхлэх гээд ингээд мөнгө байхгүй ингээд суучихсан. Та нар энийг мэдэхийн дээдээр мэдэж байгаа. Одоо жишээлбэл хамгийн наад зах нь гэхэд урьд Хятад 3 жил гаран хилээ хааж байгаад нээгээд одоо бүх ААН иргэддээ ингээд хавтгайд нь зээл өгсөн. Бодвол өөрөө сонссон байх.

Тийм учраас одоо ингээд энэ Загийн газрын хувьд ч гэсэн хил боомтоо анхаараад экспорт бол хангалттай явж байгаа валют их хангалттай орж ирж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгээд энэ хэмжээгээр та нар одоо энэ зээлээ тавихгүй юм уу? Ингээд банкнууд нь бол бүх мөнгөө өөрсөд дээрээ хумьчхаад тэгээд энэнээс чинь болоод одоо ингээд улс орон чинь хавтгайдаа ингээд ажил төрөл байхгүй, ААН нь дампуурлын байдалтай ийм байна шүү дээ. Тэгээд энийг чинь одоо юу гэж ойлгох юм бэ айн? Нэг л Энэ мөнгөний бодлогоо

та нар буруу л удирдаад байх шиг байх юм. Би одоо зүгээр тэр нь буруу энэ нь буруу гэж хэлэхээсээ илүү тийм учраас энэ дээр одоо ер нь цаашдаа яг яах юм?

Дээрээс нь ахиад нэмж хэлье. Ипотекийн зээл гэж одоо ерөөсөө байхгүй болсон. Энэ ипотекийн зээл яагаад ингээд хумигдаад байхгүй болчхож байгаа юм. Энэ олон байшин барилга баригдсан хүмүүс авах сонирхолтой байна. Тэгээд ялангуяа хөдөө орон нутагт ямар ч ипотекийн зээл байхгүй.

Тэгээд Улаанбаатарын энэ түгжрэлдээ ипотекийн зээл олгоод байдаг. Тэгээд хөдөө өнөө хүмүүсээ хөдөө рүү чиглүүлэх одоо Засгийн газрынхаа бодлогын эсрэг ингээд яваад байгаа юм уу хаашаа юм. Тэгээд энэ асуудлаа 1 тусад нь ингэж оруулж ирэхгүй бол энэ одоо бид нар хүлээгээд суугаад байвал ингээд ямар ч үр дүн байхгүй ингээд наадамтай золгоод тэгээд л одоо ёстой намар болоод тэгээд дахиад л нэг ийм байдалтай л болох юм байна.

Экспорт одоо мянга нэмэгдээд ингээд та нар ингээд одоо юу гэдэг юм? Найдваргүй зээл гээд нэг гоё юм хэлчхээд ингээд ам таглаад 1.6 их наядын найдваргүй зээл байгаа гэдгийг сонсож л байсан. Тэглээ гээд одоо ингээд машинаа зогсоочхож болохгүй биз дээ? Бензин дууссан гээд. Аль нэг газраас одоо бензин хийгээд явна биз дээ машин юм чинь. Тийм юмыг одоо нэг яаж шийдэх юм? Та нар нэг юу бодож байгаа юм? Нэг хариулт авъя тэгэх үү? Тэгээд дараа нь би асууя.

Г.Занданшатар: Хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй юм байна. Эдийн засгийн байнгын хороогоор энэ асуудлыг ирэх 7 хоногт хэлэлцэнэ гэж байгаа.

Тэр үеэр тодорхой сайн ярьцаая. Энхтайван 83.

Г.Энхтайван: Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас нь эхлээд хариулаад явчихъя. Ипотекийн зээлийн хөтөлбөр 2020 онд Улсын Их Хурлаар батлагдсан ковидын хуулийн дагуу бол Төв банк энэ дээр сүүлийн 2 жил гаруй хугацаанд оролцоод явж байсан. Энэ хүрээнд 2021 онд нийтдээ 1 их наяд 2022 онд бол 700 тэрбум төгрөгийн бол ипотекийн зээлийн санхүүжилт бол гараад явсан байгаад байгаа юм. 12 сарын 31-нээр тасалбар болгож Ковидын хууль дууссантай холбогдуулан Төв банк ипотекийн зээлийн хөтөлбөр дээр санхүүжилт хийхээ зогсоосон байгаад байгаа юм. Одоогоор бол ипотекийн зээлийн эргэн төлөлтөөрөө буцаад аж арилжааны банкнууд эргэн төлөлтийнхөө хүрээнд бол санхүүжүүлээд явж байгаа. Энэ хүрээнд энэ жилийн хугац хувьд 400 орчим тэрбум төгрөгөөр бол ипотекийн зээлийн хөтөлбөр хэрэгжээд явж байгаа.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн ойролцоогоор 20 орчим хувь нь орон нутагт олгогддог. Энэ жилийн хувьд бол орон нутагт шилжин суурьшсан болон орон нутагт амьдарч байгаа иргэдэд бол ипотекийн зээлийн хөтөлбөр бол хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр урьдчилгаа төлбөрийн 30 хувь дээр бол Зээлийн батлан даалтын сан орж ирж байгаа. Мөн төсөв дээр орон нутагт шилжин суурьшсан болон орон нутагт амьдарч байгаа иргэдийн ипотекийн зээлийн хүүгийн татаасыг төсөв дээр бол суулгаж өгсөн байгаа 3 хувь.

Тэгэхээр орон нутагт бол ипотекийн зээлийн хөтөлбөр илүү чиглэгдэж, төвлөрлийг бууруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлтэй ипотекийн хөтөлбөр бол цаашдаа үргэлжлээд явна гэж тооцоолж байгаа. Төв банкны зүгээс энэ оны 2 дугаар улиралдаа багтаагаад ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол Засгийн газарт шилжүүлэхээр бол Сангийн яам Барилга, хот байгуулалтын яамтай бол хамтраад

ажиллаж байна. Мөнгөний бодлогын хувьд бол сүүлийн 3 жилийн хугацаанд дэлхий даяараа энэ цар тахалд нэрвэгдсэн. Цар тахлын хүндрэл гүйцэд арилаагүй байх үед манай улсын хувьд бол энэ урд хөршийн одоо 0 ковидтой холбоотойгоор хил, гаальтай холбоотой бол экспортын орлого дээр хүнд цохилт авсан.

Мөн дараа нь дараалаад одоо хойд хөрштэй холбоотой геополитикийн энэ дайны асуудал үүссэнтэй холбогдуулан бол бас дараалсан ийм 3 цохилт авсны үндсэн дээр эдийн засаг тодорхой хэмжээгээр хүндрэлийг амссан. Энэ хүрээнд бол одоо энэ хүндрэл нь ихэнхдээ бол инфляцаар дамжиж төлбөрийн тэнцлийн алдагдал инфляц ханшийн дарамт болж бол эдийн засагт учирсан. Тэгээд Төв банкны зүгээс иргэдийн орлогыг хамгаалах өрхийн амьжиргааг дэмжих хамгийн наад одоо нэн тэргүүний бодлого бол инфляцыг Төв банкны зорилтот түвшинд хүргэж бууруулах чиглэлээр бол үйл ажиллагаагаа чиглүүлсэн байгаад байгаа. Энэ дээр бол мэдээж зээлийн тасалдал бий болсон. Зээл буурсан, ханшийн одоо дарамт эдийн засаг дээр учирсан. ААН-үүд бол хүндэрч байгааг бол Төв банкны зүгээс бол ойлгож байгаа. Гэхдээ энэ ер нь бол бодлогын сонголт юм.

Бид бүхэн бол нэгдүгээрт инфляцаа барих юм уу, хоёрдугаарт, эсвэл одоо зээлийн өсөлтөө барих юм уу гэдэг бодлогын сонголт байгаа юм. Тэгээд энэ дээр бол төв банк бол өөрөө хуулиар олгогдсон мандатынхаа хүрээнд бол инфляцыг бууруулж байгаа юм. Инфляцыг нэн тэргүүнд нам дор түвшинд барихгүй бол энэ нь эргээд өрхийн аж ахуй өрхийн амьжиргаан дээр хүнд цохилт аваад байгаа юм. Манай эдийн засаг өөрөө одоо ойролцоогоор бол одоо 44 их наяд байлаа гэхэд энэний 60 орчим хувь нь өрхийн амьжиргаа өрхийн эдийн засаг байдаг. Тэгэхээр 12-оос 14 хувийн инфляц гэдэг маань өөрөө энэ 30 гаруй их наядын

өртөгтэй энэ өрхийн эдийн засаг дээр том цохилт аваад зөвхөн иргэдийн халааснаас 3-4 их наяд төгрөгийг бол инфляцаар дамжуулаад ингээд авчаж байгаа гэсэн үг. Тэгэхээр бол төв банкны зүгээс энэ бодлогын хувьд одоо шийдвэрүүдээ эрэмбэлээд нэгдүгээрт нь инфляцаа тогтворжуулъя.

Дараа нь зээлийн өсөлт болон одоо бусад асуудлуудаа ингээд.

Г.Занданшатар: Эдийн засгийн байнгын хороон дээр ирэх 7 хоног хэлэлцэнэ шүү дээ. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай бол шууд холбоогүй юм байна. Дэлгэрсайхан гишүүнээ та хэд Эдийн засгийн байнгын хороон дээр ярилц.

Эдийн засгийн байнгын хороон дарга хариулчихъя.

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

Энэ 4 сард Монголбанк жилийнхээ тайланг тайлагнана. Их Хурал тайлагнана. Энэ дээр бол одоо Эдийн засгийн байнгын хороон дээр мөн чуулганаар оруулж ирж нэлээн энийг дэлгэрэнгүй энэ дээр ярилцана. Энэ дээр одоо манай Дэлгэрсайхан гишүүн дахиад энийгээ одоо гүнзгийрүүлж асууж бүүр тодорхой хариултуудыг авна. Энэ дээр Монголбанкнаас бүрэн бүрэлдэхүүнээрээ байна. Ерөнхийлөгч нь байх ёстой. Энхтайван Ерөнхийлөгч анхаараарай энэ дээр. Бид нарт одоо тайлангаа өгөнгүүт бид нар бас гишүүддээ Байнгын хороон дотроо эхэлж мэдээллийг нь одоо түрүүлж сайн хэлэлцэж бас энэ дээр анхааралтай хандаж ажиллана гэж үзэж байгаа. Тэгэх дээр энэ дээр бол энэ үеэр та энийгээ асууж болох юм.

Дээрээс нь ерөнхийдээ өнөө өнөөдрийн энэ Монголбанкны явуулж

байгаа бодлого нь бол одоо бид нар бас ярилцсан. Монголбанкны Ерөнхийлөгчтэй ярьсан. Ер нь энэ дэлхийн бусад улсуудын төв банкнуудын явуулж байгаа бодлого бол бас ерөнхийдөө инфляцаа барих энэ бодлогоо одоо түлхүү барьж явж байгаа. Өнөөдөр гэхэд түрүүчийн 7 хоног гэхэд Америкийн Төв банк бодлогынхоо хүүг бас нэмсэн. Тэгээд энэ дээрээ бол Төв банк инфляцаа барья гэж ингэж энд чиглэж бодлого явуулж байгаа юм байна лээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууж үг хэлье.

Б.Баттөмөр: Би яах вэ эрдэнэсийн сангийн талаар энэ юмнуудаа уншиж танилцлаа. Сая манай гишүүд асуугаад гол юунуудаа хариул авчихлаа. Би энд зүгээр алтан дээр ярих гээд. Энэ 2022 оны гүйцэтгэлээр би ойлгохдоо 21.9 тонн алт авсан гэж ойлгож байгаа. Одоо тайлан дээр ирээд ил гараад ирэх байх. Та нар одоо 2023 онд улсын төсөвт тусгахдаа 17 тонн алт авна гэсэн. Яагаад ингээд энэ 4 бараг 5 тонноор ингээд буурчхаж байгаа юм бэ? Хил гааль нээгдлээ хулгай дийлэхгүй гээд ингэж байгаа юм уу эсвэл одоо алтны үйлдвэрлэл тодорхой ийм эрсдэл байна. Энэ багасна гэсэн ийм тооцоо байна уу? Эхний 3 сарын байдлаар хэчнээн хэмжээний алт худалдаж авч байна гэсэн ийм 1 дэх асуулт байгаа юм. 2 дахь асуудал бол юу гэхээр зэрэг энэ алтны үнэ бол хэзээ ч буурахгүй. Одоо энэ валютууд юань, доллар энэ тэр ингээд ханиш энэ тэр нь буурч байна. Бусад валюттай харилцах. Тэгэхээр алттай бүх юм харьцуулж явдаг учраас алтны үнэ ханиш буурахгүй. Тэгэхээр энэ хямрал цаашаа үргэлжилнэ ээ гэж байгаа шүү дээ. Тэгээд энэ үед бол юу гэхээр энэ алтны үнэ цэн бол их тодорхой түвшинд байна. Энэ дээр бид нар их сайн ажиллах ийм шаардлагатай л даа. Манай энэ далд эдийн засгийг чинь одоо нөхцөлдүүлж байгаа гол юм бол энэ алт байгаа шүү дээ. Нэг аманд улсууд очоод алт ухдаг. Нэг гэр бүлийн амьдрал дээшилдэг. Гэтэл баялаг

нь ард түмний мэдэлд байдаг. Тэгээд одоо алт ухсан улсууд одоо Монголд байхгүй асар их хэмжээний тийм баян болчихсон. Ард иргэдийн 42 орчим хувь нь ядуурчихсан байгаад байдаг. Энэ тэгээд энэ алтан дээр одоо яадаг вэ гэхээр зэрэг ерөөсөө тэр ААН-үүд нь тушаадаггүй. Хувь хүн тушаагаад байдаг. Тэр хувь хүн тушаадаг нь ямар учиртай вэ гэхээр нөгөө орлогыг нь тодорхойлох боломжгүй одоо татвар гэдгээр тушаадаг. АМНАТ төлдөггүй. ААН-ийн орлогын албан татвар төлдөггүй. Тэгээд энийг манай Монголбанк одоо ингээд л манай Сангийн яам хоёр хоёулаа мэдэж байгаа мөртөө ингээд л өөгшүүлээд л яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ одоо тэр олборлосон улсуудаас нь авах чиглэлээр та нар юу хийж байгаа вэ? 2 дахь асуудал байна.

Гурав дахь асуулт юу гэхээр 2021 оны статистикаар Оюутолгой 1.9 тэрбум долларын одоо зэсийн баяжмал экспортлсон гэж байгаа. Энэнээс 300 орчим сая доллар нь одоо алт шүү гээд. Энийг манай Сангийн яам, Монголбанк одоо тийм ээ л гээд ингээд явж байгаа юм.

Тэгээд энэ лаборатори эд нар дээрээ та нар цаашидаа хамтарч ажиллах гэж байна л даа. Ер нь одоо энэ 300 гэдгийг та нар баталгаажуулж байгаа юм уу? 300 юм уу, 500 юм уу? Ер нь цаашидаа энэ Оюутолгойн энэ баяжмалыг дагаж гарч байгаа энэ алтан дээр та нар ямар бодлого барих юм бэ? Нэгэнт Монгол Улсын Засгийн газар Монголын ард түмэн 34%-ийг нь эзэмшиж байгаа бол энэ гарч байгаа баялгийнхаа энэ бүтцийг та нар бүтэц одоо тэр ховор элемент их мундаг юмаа мэддэггүй юм гэхэд энэ алтаа та нар яаж ялгах юм бэ?

Энэ дээр та нар ямар бодлого одоо барьж байгаа юм бэ? Энэ Оюутолгойд энэ 300 сая долларын алтыг одоо Монголоор дамжуулах чиглэлд та нар юу

хийх юм бэ? Яах вэ одоо сая өчигдөр уржигдар 12 сая доллар Монголбанк арилжааны банкнууд худалдаж байна л даа. Энэ одоо сүүлийн хэдэн жил ч юм. Одоо би лав л хэдэн жил гараагүй л нэг тийм сайн үзүүлэлт гарч байна л даа. 4 сая доллар худалдаад 12 сая доллар худалдаж авч байна л даа. Тэгэхээр энэ алтны мөнгийг Монгол банкаар дамжуулах мөнгийг Монголбанкаар эсвэл алтыг одоо тэр Оюутолгойн алтыг бид одоо авдаг ийм яриа хэлцэл ийм сэдлүүдийг та нар хийж байна уу үгүй юү?

Г.Занданшатар: 83 Энхтайван.

Г.Энхтайван: Баттөмөр гишүүний асуултад тодруулъя.

2023 онд төв банкны зүгээс бол 20-22 тонн алт худалдан авах хүлээлттэй байна. 3 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар оны эхнээс бол 2 тонн алт худалдан авсан байгаа. Энэ нь бол өмнөх жилүүдийн одоо яг мөн үетэй харьцуулбал буурсан. 2022 оны мөн үеийн байдлаар бол жишээлбэл 3.22 тонн, 2021 онд бол 2.8 тонн алт худалдан авсан байна. Яг өнөөдрийн байдлаар бол яг 2 тонн алтыг бол худалдан авчхаад байна.

Тэгэхээр бол жилийн гүйцэтгэлээрээ 22-23 тонн орчим алт худалдан авах болов уу гэсэн бол хүлээлттэй байна. Төв банкны зүгээс бол ковидын хуулийн хүрээнд бол алт-2 хөтөлбөрийг хэрэгжүүлж ААН-үүдэд бол санхүүжилт олгоод явж байсан. Энэ хүрээнд сүүлийн 2 жил алтны худалдан авалт бас харьцангуй өндөр дүнтэй байсан. Ковидын хуулийн хүрээнд олгосон санхүүжилт бол нийтдээ 505 орчим тэрбум төгрөгийг ААН-үүдэд урт хугацаатай болон богино хугацаатай санхүүжилтийн хүрээнд олгож явсан. Энэ хөтөлбөр бол тэгэхдээ яах вэ хуулийн дагуу өнгөрсөн оны төгсгөлөөр бол дууссан байгаад байгаа. Мөн өнгөрсөн онд батлагдсан тэр гол нэрийн бараа

бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах гээд нөгөө урт нэртэй хуулийг батлагдсан. Энэ хүрээнд бол төв банкны зүгээс бол Лондоны одоо металлын биржээс 5%-ийн илүүтэй үнээр бол алт худалдан авсан байгаад байгаа. Яг энэ хүрээнд нийтдээ 133 орчим тэрбум төгрөгийг бол яг энэ илүү төлсөн тав орчим хувь дээр нь бол илүү төлсөн. Энэ нь эргээд алт олборлолтын алтны одоо секторын бизнесийн үйл ажиллагааг дэмжих тийм хөшүүрэг болсон гэж бол үзэж байгаа.

Оюутолгойтой холбоотой асуудал дээр бол төв банкны зүгээс тухай бүрдээ бол Оюутолгой компани нь төв банканд бол валют арилжаан дээр оролцоод доллар бол нийлүүлээд явдаг. Яг энэ хүрээнд Оюутолгой бол 2021 онд 873 сая долларыг бол төв банканд нийлүүлсэн. 2022 онд бол 1.3 тэрбум, 2023 онд одоогоор бол 443 орчим сая долларыг бол нийлүүлчхээд явж байгаа. Оюутолгойн баяжмалтай холбоотой асуудал дээр бол одоо баяжмал бол хүдэр хэлбэрээрээ бол алт нь хамт гараад явж байгаа. Энэ дээр бол хилээр гарахад нь Стандартчилал хэмжил зүйн сорьцын хяналтын улсын алба энэ дээр бүртгэлжүүлээд сорьцыг нь тогтооход бол хилээр гаргадаг гэж бол ойлгож байгаа.

Төв банкны зүгээс бол Оюутолгой компанитай бол тухай бүр дээр яриа хэлэлцээ оруулаад алтаа Монголбанканд тушааж байх тухай бол хэлэлцээрийг анх одоо Оюутолгой компани нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулаад эхэлснээс хойш одоо 2009 оноос хойш л энэ дээр бол яриа хэлэлцээрийг бол хийгээд л явдаг. Энэ бол Оюутолгой компанийн зүгээс бол тавьдаг асуудал нь бол энэ тухайн одоо Оюутолгойн гэрээг одоо тогтвортой байдлын гэрээ буюу том хөрөнгө оруулалтынхаа гэрээний хүрээнд бол энэ үйл ажиллагаа зохицуулагдаад явж байгаа гэсэн. Тийм тайлбарыг бол тухай бүрдээ хийдэг ээ.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Батэрдэнийн урилгаар Булган аймгийн Хялганат тосгоны ЕБС-ийн Хараацай чуулгын бүжигчин сурагчид, багш нарын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Пүрэвдорж гишүүний дуугүй бай. Та бүхэндээ сурагчдадаа сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүсье ээ. Урлаг спортын бас өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Г.Занданшатар: 1 минут Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууна.

Б.Баттөмөр: Энэ 2023 онд 20-22 тонн алт авах гэж байгаа бол зүйтэй. Одоо хүрсэн түвшнээс буурч болохгүй. Манайх хамгийн гол нь Сангийн яам улсын төсөв боож орж ирэхдээ 17 тонн гэж орж ирсэн шүү. Ийм байж болохгүй. Энэ дээр би шүүмжлээд одоо болоогүй юм. Сая яг тэр 300 сая долларын алт чинь та нар яаж тооцож гарч ирж байна. Яаж тооцдог юм бэ? Энийг одоо энэ дээр та нарт тооцоо мооцоо юм байна уу үгүй юу? 2023 оны одоо 1 дүгээр улирлын статистикаар урдахаас буурчихсан байна гэж байгаа юм. Энэ чинь хил нээгдээд нөгөө алтны хулгай чинь яваад байгаа юм биш биз дээ? Гаднын нэг хулгай хийдэг нөхрийн гэрийг ухсан чинь 15 тонн алт гарсан. Тэрний 7.5 нь Монголоос гарал үүсэлтэй гээд энэ ном дээр биччихсэн байна шүү. Хариуцлагатай улсууд одоо гарын үсгээр тавьчихсан байна шүү дээ тэ та нар харсан биз дээ тэ?

Тэгээд энэ хулгайтай яаж тэмцэх юм бэ? Та нар энэ цагдаа, энэ гааль, энэ холбогдох.

Г.Занданшатар: 83 Энхтайван Дэд ерөнхийлөгч.

Г.Энхтайван: Баттөмөр гишүүний асуултад тодруулъя. Тэр Оюутолгойтой холбоотой тэр 300 сая долларын алт гарч байна гэдэг дээр бол хилээр гарахад нь баяжмал дээр нь бол Стандартчилал хэмжил зүйн газрын Улсын сорьцын хяналтын улсын алба хяналтаа тавиад сорьцолдог. Тэгээд тэр сорьцолсон дүнгээрээ гаалийн мэдээн дээр бүртгэгдээд гаалийн мэдээгээр бол 300 сая доллартой тэнцэх хэмжээний алт гарсан гэдэг мэдээлэл бол орж ирж байгаа. Энэ дээр бол мэдээж энэ бол яг Сорьцын хяналтын улсын албанаас гаалийн мэдээн дээр нэгтгэгдэж байгаа дүн байгаад байгаа. Энэ нь бол яг сорьц одоо түүхий хэлбэрээрээ гараад гадаад улсад очоод энэ төрөл дахиж сорьцлогдоод, цэвэршүүлэгдээд, цэвэр алт болоод орж ирж байгаа. Энэ алтыг бол буцааж Монгол банканд тушаах одоо Монголбанканд худалдах талаар бол мэдээж Монголбанк бол Оюутолгой компанитай тухай бүрдээ бол ярилцаад явдаг. Ер нь бол энэ чиглэлээр зайлиггүй цаашидын бодлогын одоо томоохон шийдвэр гаргах бол шаардлагатай байгаа.

Г.Занданшатар: Тэгээд Хөрөнгө оруулалтын гэрээ. Эдийн засгийн байнгын хорооны дарга л хариулж болно. Байнгын хорооны санал, дүгнэлт учраас.

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүний асуусан асуултад нь бас нэмээд хариулчихъя.

Дээрээс нь Энхтайван Ерөнхийлөгч тэр одоо сая ковидын үеэр чинь бид нар Монголбанк чинь 5 хувийн илүү үнээр тийм үү? Лондонгийн биржийн үнэ дээр 5 хувийн нэмэгдэлтэй алт худалдаж авах ийм бодлого арга хэмжээ явуулсан юм шүү дээ.

Энэний үр дүн зүгээр яаж гарсан юм бас нэмээд хариулчхаарай. Энэ одоо

энэ зогссон юм уу энэ энэ 5 хувиар нэмж авч байгаа юм уу? Энэ 95 хувийн илүү үнээр авахаар зэрэг энэ одоо тэр өмнө тушааж байсан алтны тушаал нэмэгдэхэд шууд одоо энэ нөлөөлсөн үү үгүй юү? Энэ дээр та нар ямар судалгаа, дүгнэлт хийж байгаа юм гэдгээ нэмээд хэлчээрэй. Ер нь бол энэ алтны хулгайтай холбоотой асуудлаар бол энэ Монголбанкны асуудал гэхээсээ бид нар одоо бусад энэ гаальтай, цагдаа дээрээс нь ялангуяа одоо манай энэ Их Хурал дотор байгаа тэр Байгаль хамгаалах консервац бүлгийнхэн бол одоо ажиллаж байгаа. Азийн сангийнхан.

Г.Занданшатар: 83 Цэрэнпунцаг гишүүн гүйцээж хариулъя.

Эрдэнэсийн сантай холбоотой биш Эдийн засгийн байнгын хороогоор бол тусдаа л хэлэлцмээр байна. Алт эдийн засаг энэ тэрийн асуудал.

Ц.Цэрэнпунцаг: Энэ дээр бол тэр алтны хулгайтай тэмцэх асуудал бол өөр одоо бусад олон энэ төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах ийм ажил байгаа юм. Тэгээд Энхтайван тэр сая энэ хувийн нэмж Лондоны биржийн үнээр авч байгаа. Энэ одоо үргэлжилж байна уу? Энэний нөлөө яаж тусаж байгаа юм.

Тэгээд та нар энэ нь одоо энийгээ одоо хэзээ зогсоох юм? Энийг одоо зогсоочихсон юм уу? Зогсоочоод тэгээд энэ алтныхаа тэр одоо энэ таамаглаж байгаа одоо худалдан авах таамаглалаа одоо та нар ингээд нааш цааш нь хөдөлгөөд байгаа юм уу? Хариулаадах.

Г.Занданшатар: Сэргэлэн гишүүн ээ. Одоо санал хураалт Энхтайван ерөнхийлөгч гүйцээгээд хариулчихъя. 83.

Г.Энхтайван: Өнгөрсөн оны 4 сарын 15-ны өдөр батлагдсан Гол нэрийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомсдолоос сэргийлэх тухай хуулийн одоо

5.1.6-гийн хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын зах зээл дээрээс олборлосон алтыг Лондонгийн биржийн үнээс 5 хувиар илүүтэйгээр худалдаж авахаар зохицуулалт орсон байгаад байгаа. Энэ хүрээнд бол яг энэ хуулийн үйлчлэх хүрээнд 1.8 тонн алтаар илүү алт тушаагдсан. Яг энэ 1.8 тонн алттай холбогдсон тэр хувийн нэмэгдэл дээр төв банкны зүгээс бол 133.4 тэрбум төгрөгийг нэмэлтээр бол санхүүжилтээр олгосон байгаад байгаа.

Тэр хил, гааль алтны хулгайтай холбоотой асуудал дээр бол төв банк холбогдох хууль хүчний байгууллагууд болон одоо ТЕГ, хилийн одоо гаалийн албатай бол тухай бүрдээ бол хамтраад ажиллаад явдаг. Хилээр хулгайгаар алт гарч байгаа хэмжээ бол маш бага байдаг маш бага. Энэ дээр бол сүүлийн 2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад бол дунджаар бол маш цөөхөн хүмүүсийн ойлгоод байдаг шиг тийм өчнөөн олон килограммаараа алт одоо хулгайгаар хил давуулах гэж оролдсон тохиолдол ерөөсөө гарч байгаагүй.

Энэ дээр тухай бүрд нь бол төв банкны зүгээс бол хяналт тавиад явдаг. Энэ жилийн хувьд алт тушаалт яагаад өмнөх жилүүдтэй харьцуулбал бага зэрэг бага байна вэ гэхээр алтны одоо гол сезон бол оны 1 дүгээр улирлын төгсгөлөөс буюу 4 дүгээр сараас эхэлдэг. Төв банкны зүгээс бусад олборлогч ААН-үүдээс авч байгаа мэдээллээр бол энэ жилийн хувьд бол оны 2 дугаар улирал, 3 дугаар улирал дээр алт олборлолт бол бас харьцангуй өмнөх жилүүдийн түвшинд хүрээд гүйцээд ирэх юм байна. Оны төгсгөлөөр ингээд 22-23 тонн алт худалдаж авах тийм одоо хүлээлттэй байна гэдэг тооцооллыг бол ААН-үүдийн зүгээс бол өгч байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахад бэлдэнэ үү. Энэ Монгол банкны санаачилгаар энэ Энхтайван дэд ерөнхийлөгч нар оруулж ирээд хуучин бол энэ эрдэнэсийн сан Мөнгөн тэмдэгтийн нөөцийн тухай болон Нөөцийн сангийн байршил тэдгээрийн хамгаалалтын тухай мэдээлэл бол төрийн ба албаны нууцын тухай хуулиар нууц байсан. Нууцад хамааруулдаг учраас нууцаар хэлэлцдэг байсан.

Энийг ер нь ил тод болгох хэрэгтэй олон түмнийг хяналтад оруулах хэрэгтэй саяын гишүүдийн яриад байгаа тэр далд асуудлууд байгаа учраас ингээд ил болгосон. Тэгээд ийм учраас ил хэлэлцэж байгаа. Тэгээд ийм учраас тэр тухайн мэдээллийг төрийн болон албаны нууцад хамаарахгүй болгосон хууль батлагдаж хүчин төгөлдөр болсон учраас нээлттэй хэлэлцэж байгаа юм гэдгийг бас тодруулъя.

Ингээд санал хураалт явуулна. Ингээд өглөөний хамгийн эхний санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явуулъя.

Энэ санал хураалтаар техникийн бүрэн бүтэн байдал болон ирцийн мэдээллийг давхар шалгаж байна гэсэн үг. Хяналтын санал хураалт.

Ингээд Байнгын хорооны саналаар тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 29 гишүүн дэмжиж 64.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд Ажлын хэсэгт баярлалаа.

Монгол Улсын эрдэнэсийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 онд төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн 2023 оны төсвийн тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын үндсэн сангийн орлого үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийг хавсралтаар баталсугай.

Хавсралтыг унших ёстой юу? Шаардлагагүй биз дээ? Энэ Чингис хааны баримал алтан тамганы хамт бүтээл гэсэн л юм байна. Чингис хааны музейд энэ л нэмэгдэж байгаа юм байна.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан Өндөрлөснийг мэдэгдье.

10:58

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА